



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/265

Сүхбаатар сум

Г “Хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт”  
хэрэг, зөрчилтэй тэмцэх аян” өрнүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 “е”, 29.1.3 “н”, 30 дугаар зүйлийн 30.1.5, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, 16.2.10, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.3, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 31 дүгээр зүйлийн 31.1, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 4.1, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйл, Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоол, 2019 оны 355 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд ашигт малтмал эрэх, хайх, олборлох, ашиглах үйл ажиллагаа эрхэлж буй бүх төрлийн аж ахуйн нэгж, иргэдийг хяналт, шалгалтад хамруулж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илэрсэн гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, хуулийн дагуу шалгаж шийдвэрлэх зорилгоор “Хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх аян”-ыг 2021 оны 9 дүгээр сарын 06-ны өдрөөс 12 дугаар сарын 06-ны хооронд зохион байгуулсугай.

2. Хяналт, шалгалтыг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд шуурхай, үр дүнтэй зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хяналт, шалгалт хэрэгжүүлэх удирдамжийг хоёрдугаар, аян, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Дээрх аян, арга хэмжээнд шаардлагатай 15,143,562 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс /О.Мөнхбаяр/-т зөвшөөрсүгэй.

4. Аяныг дурдсан хугацаанд үр дүнтэй зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллах, явц, үр дүн болон төсвийн зардлыг тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч /Мэргэжлийн хяналтын газрын дарга/, нарийн бичгийн дарга /Цагдаагийн газрын дарга/ нарт тус тус үүрэг болгосугай.


5. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байгаа албан хаагч нарт Коронавируст цар тахал /Ковид-19/-ын халдвараас урьдчилан сэргийлж, халдвар хамгааллын дэглэмийг бүрэн баримтлан ажиллахыг үүрэг болгосугай.

430810647

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажлын хэсгийн үйл ажиллагаанд мэргэжил, аргазүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ж.Сайнцог/-д даалгасугай.

ДАРГА

Ш.ОРГИЛ

A rectangular official stamp with a double-line border. Inside the stamp, there is a handwritten signature in the center. On the left side of the stamp, the name 'Ж.Сайнцог' is written vertically. On the right side, the name 'Ш.Оргил' is written vertically. The stamp is placed over the text 'ДАРГА' and 'Ш.ОРГИЛ'.

Аймгийн Засаг даргын 2021 оны  
09 сарын 08 -ны өдрийн 1129 дугаар  
албан тоотын нэгдүгээр хавсралт

Хяналт, шалгалтыг зохион байгуулах  
ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга

Нарийн бичгийн дарга:

Сэлэнгэ аймаг дахь Цагдаагийн газрын дарга

Гишүүд:

Аймгийн Ерөнхий Прокурор, Хууль цаазын шадар зөвлөх

Сэлэнгэ аймаг дахь Тагнуулын газрын дарга

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Аймгийн Газрын харилцаа, барилга хот, байгуулалтын  
газрын дарга

Аймгийн Онцгой байдлын газрын дарга

Аймгийн Засаг даргын 2021 оны  
09 сарын 08 -ны өдрийн 126 дугаар  
албан тоотын хоёрдугаар хавсралт

**"ХУУЛЬ БУСААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛТЭЙ  
ТЭМЦЭХ АЯН"-Ы УДИРДАМЖ**

2021.09.01

Сүхбаатар сум

**Нэг. Зорилго:**

Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд ашигт малтмал эрэх, хайх, олборлох, ашиглах үйл ажиллагаа эрхэлж буй бүх төрлийн аж ахуйн нэгж, иргэдийг хяналт, шалгалтад хамруулах, явц, үр дүнг олон нийтэд мэдээллэх, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илэрсэн гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, хуулийн дагуу шалгаж шийдвэрлэхэд оршино.

**Хоёр. Хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэрэг, зөрчилтэй  
тэмцэх аяны хамрах хүрээ:**

Тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа эрхэлж буй ахуйн нэгж, иргэн, бизнес эрхлэгч, хууль бусаар ашигт малтмал олборлож буй аж ахуйн нэгж, иргэн, нөхөрлөл, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллагууд тус тус хамрагдана.

**Гурав. Хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх  
аян үргэлжлэх хугацаа:**

2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн 12 дугаар сарын 06-ны өдрийг хүртэлх хугацаанд хэрэгжүүлнэ.

**Дөрөв. Хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх  
аяны хүрээнд хийж гүйцэтгэх ажлууд:**

5.1. Аяны удирдамжийн хүрээнд төлөвлөгөө боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулах, шаардлагатай төсөв, хөрөнгийг шийдвэрлүүлэх;

5.2. Аяны удирдамж, явц, үр дүнг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тухай бүр сурталчилах, мэдээлэх;

5.3. Хяналт, шалгалтыг дараах хууль тогтоомж, эрх зүйн акт, чиглэлийн хүрээнд зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллана. Үүнд:

- Байгаль орчныг хамгаалах тухай хууль,
- Ашигт малтмалын тухай хууль,
- Газрын тухай хууль,
- Усны тухай хууль,
- Ойн тухай хууль,
- Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль,
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль,
- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоол "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын хэрэгжилт болон 2019 оны 355 дугаар тогтоолын хэрэгжилт,


- Аймгийн ИТХ-ын 2007 оны “Бодлого, журам батлах тухай” 39 дүгээр тогтоолын хэрэгжилт,
- Байгаль орчны менежментийн 2021 оны төлөвлөгөө, түүний хэрэгжилт,
- Ашиглалтын үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөө, түүний хэрэгжилт,
- Газар, ус ашиглах дүгнэлт гэрээ,
- Шав тэмдэг тавиулсан тухай акт,
- БОМТ-нд тусгагдсан техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн явцтай танилцах,
- Үйл ажиллагааны бичиг баримтын бүрдэл шалгах,
- Үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгж, байгууллагуудад зөвлөмж, чиглэл өгөх,
- Шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагааг түр зогсоох,
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох,
- Олон нийтэд сурталчилах, мэдээлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

**Тав. Хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх аяны үр дүнг танилцуулах:**

Аяны хүрээнд хэрэгжүүлж буй хяналт шалгалтыг тухай бүр тусгайлан төлөвлөж, хэрэгжилтийг хангах ба үр дүнг нь аймгийн Засаг даргад илтгэх хуудсаар танилцуулж ажиллана.

Ажлын хэсгийн хэрэгжүүлсэн аяны удирдамжийн нэгдсэн дүнг 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдөр аймгийн Засаг даргад илтгэх хуудсаар танилцуулж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Аймгийн Засаг даргын 2021 оны  
09 сарын 08 ны өдрийн А/БС дугаар  
албан тоотын гуравдугаар хавсралт



ХУУЛЬ БУСААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛТЭЙ  
ТЭМЦЭХ АЯН ХИЙХ ЗАРДЛЫН ТООЦОО

2021.09.01

Сүхбаатар сум

№	Зардлын төрөл	Зардал /төгрөг
1	Шатахууны зардал	15,143,562 төгрөг
	Нийт дүн	15,143,562 төгрөг

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН МАРШРУТ

НАМАР /3 УДАА/

Нэг. Сэлэнгэ аймгийн Ерөө сум.

1. Сэлэнгэ аймгийн төвөөс - Ерөө сум -90 км
2. Ерөө- Бугант тосгон -75 км
3. Бугантын төвөөс- Толгойт, Хайлааст, Сангийн гол, Шаварт, Уулзвар  
км -125
5. Сангийн- Гозон шар -15 км
6. Гозон шар- Их бага Ажир -35 км
7. Их Ажир- Буурал, Их алт -100км
8. Их алт-Цонхлонгоор- Бэрлэг, Ялбагийн гол -80 км
9. Ялбагийн гол- Ургаач, Мухар, Бага мухар -50 км
10. Ялбагаас- Могойн гол, Цамхаг, Өлөнт, Харганат -70 км
11. Харганат- Ерөө сум -135 км
12. Ерөө сум- СБ -90 км

Нийт - 865 км

Хоёр.Сэлэнгэ аймгийн Хүдэр сум.

1. СБ-Хүдэр сум	-150 км
2. Хүдэрийн төвөөс -Уялга, Амж	-70 км
3. Уялга- Хэрсийн гол км	-127
10. Хэрсийн гол-Сүхбаатар сум	-210 км
	Нийт - 557
	км

Гурав. Сэлэнгэ аймгийн Баянгол сум.

1. СБ-Баянгол сумын төв	-175 км
2. Баянгол сумаас- Шар Хөтөл	- 80 км
3. Шар Хөтөл-Нарангийн гол	-160 км
7. Нарангийн гол-Тариатын ам	-50 км
8. Тариатын ам- Урт булаг	-120 км
8. Урт булаг- Баянгол сумын төв	-120 км
9. Баянгол сум-Цагаанчулуут, Их Даширын хөндий	-135 км
10. Цагаан чулуут –Бороо	- 8 км
11. Бороо-Баянгол сум	- 35 км
12. Баянгол сум-Сүхбаатар сум	-175 км
	Нийт-1058 км

Дөрөв. Сэлэнгэ аймгийн Мандал сум.

1. Сүхбаатар сум -Мандал сумын төв -235 км	
2. Мандал сумаас – Наран- Шар нарст	-80 км
3. Наран-Тэрэгт, Шаварт	-85 км
4. Тэрэгт-СБ	-300 км
	Нийт-700 км

Тав. Сэлэнгэ аймгийн Орхонтуул сум

1. СБ- Орхонтуул	-230 км
2. Орхонтуул- Тоорой мод	- 80 км
3. Тоорой мод- Цагаангозгор	-95 км
4. Цагаангозгор- Чонын ам	- 45 км
5. Чонын ам- Орхонтуул	- 110 км
6. Орхонтуул-СБ	- 230 км
	Нийт- 790 км

Зургаа. Сэлэнгэ аймгийн Түшиг сум

1. СБ- Түшиг сум	- 130 км
2. Түшиг- Ухмалын ам	- 60 км
3. Ухмалын ам- Улаан-Овоогийн уурхай	- 65 км
4. Улаан- Овоогийн уурхай- Шар нарст	- 70 км
5. Шар нарст- Түшиг сум	- 80 км
6. Түшиг сум- СБ сум	- 130 км
	Нийт- 535 км

ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ЯВАХ ГАЗАР, МАРШРУТ

№	Сумын нэр	Явах чиглэл	Явах км	Намар 3 удаа
1	Баянгол сум	Шар Хөтөл, Нарангийн гол, Тариатын ам, Урт булаг, Цагаанчулуут, Бороо, Таширын нуруу,	1058	
2	Мандал сум	Наран, Шар нарст, Тэрэгт, Шаварт, Уртын ам	700	
3	Орхонтуул сум	Орхонтуул сум, Тоорой мод, Цагаан гозгор, Чонын ам	790	
4	Түшиг сум	Ухмалын ам, Улаан-Овоо, Шар нарст	535	
5	Хүдэр сум	Хүдэр сум, Уялга, Амж, Хэрсийн гол, Монгол алт, Нуурын орд, Бүдүүний гол, Шоргоолж, Жалга	557	
6	Ерөө сум	Ерөө сум, Бугант тосгон, Толгойтын гол, Хайлааст, Сангийн гол, Шаварт, Уулзвар, Сангийн гол, Гозон шар, Их Бага Ажир, Буурал, Их алт, Бэрлэгийн цагаан тохой, Ялбагийн гол, Ургаач, Бага мухар, Могойн гол, Цамхаг, Өлөнт, Харганат	865	
	Нийт		4505 км	13515 км



## ШАТАХУУНЫ ЗАРДАЛ

№	Ажиллах газар	Явах км	100 км-т зарцуулах шатахууны норм /л/	Нийт дүн /төг/
1	Орхонтуул, Баянгол, Мандал, Түшиг сумын нутаг дэвсгэрт	3083 км	15 л х 2490 төг	1,151,501
2	Хүдэр, Ерөө	1422 км	15 л х 2490 төг	531,117
	<b>Нийт дүн</b>	<b>4505 км</b>		<b>1,682,618</b>

Шатахуун 1 удаа-1,682,618\*3 машин=5,047,854 төгрөг

5,047,854\* 3 удаа=15,143,562 төгрөг